



## МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

**Дугаар: 2011/10**

**Мөрдөх огноо: 2011 оны 10-р сарын 26**

**Эмбарго: 2011 оны 10-р сарын 25-ны Мягмар гаригийн 11:00 цаг хүртэл**

Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2011 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хурлаас бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 12.25 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Инфляцийн хурд нэмэгдэж, илүү олон бараа үйлчилгээг хамрах боллоо. ҮСХ-оос 2011 оны 9 дүгээр сарын байдлаар ХҮИ-ээр хэмжсэн инфляци улсын хэмжээнд жилийн 10.5 хувь, Улаанбаатар хотынх жилийн 11.9 хувьд тус тус хүрснийг мэдээлэв.

Төсвийн зардал хурдтай тэлж, Хүний хөгжил сангаас бэлэн мөнгө олгож, зээлийн өсөлт хурдасч байгаа зэрэг нь нийт эрэлтийг нэмэгдүүлж байна. Нийт нийлүүлэлт болон эдийн засгийн бодит хүчин чадал дорвитой өсч амжаагүй байхад нийт эрэлт ийнхүү огцом өсөх нь суурь үнэ өсөх дарамтыг бий болгож байна. Үүнийг хүнснээс бусад барааны үнэ оны эхнээс тасралтгүй нэмэгдэн жилийн 11.3 орчим хувьд хүрээд байгаа нь нотолж байна.

2011 оны төсвийн тодотгол, 2012 оны төсвийн төсөл нь мөчлөг дагасан шинжтэй байгаа бөгөөд нийт эрэлт, улмаар инфляцийн дарамтыг ихээр нэмэгдүүлэн макро эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэх эрсдэлтэй байна. Мөн Европын улсуудын өрийн хямрал болон АНУ-ын эдийн засгийн өсөлтийн зогсонги байдал нь ирэх онуудад дэлхий нийтэд эдийн засаг, санхүүгийн таагүй орчинг бий болгох төлөвтэй байна.

Иймд Монголбанк инфляци улам эрчимжих ойрын ирээдүйн дарамтыг бууруулах, эдийн засгийн халалтыг сааруулж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор мөнгөний бодлогын хүүг өсгөх арга хэмжээг авч байна.

**МОНГОЛБАНК**